

Агуулга

I.Оршил

I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт4
I.2.Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь8

II.Мал аж ахуй

II.1.2014 оны мал тооллогын дүн9
II.2 .Малын хэрэглээний зарлага19
II.3.Төл бойжилт20
II.4.Том малын зүй бус хорогдол23
II.5. Малын хулгай25
II.6.Иргэдийн малын бүлэглэлт26
II.7.Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж27
II.8.Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт28
II.9.Малчдын тоо, насны бүлгээр31
II.10.Малтай өрх, малчин өрх32

III.Газар тариалан

III.1.Тариалсан талбай33
III.2.Хураасан ургац34

IV.Дүгнэлт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Д.Жавзанлхам

Санал хүсэлт байвал доорх

Хаягаар холбоо барина уу.

Дархан-Уул аймгийн Статистикийн хэлтэс

Засаг даргын тамгын газрын байр

E-mail:Darkhan-Uul@nso.mn

Утас:70377031 70377763

Интернет хаяг://www.nso.mn/Darkhan-Uul/

Дархан-Уул аймаг Статистикийн хэлтэс

Дархан хот 2015

ОРШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр үрийн сорт, байгаль цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2014 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг “ –ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь аймгийн удирдлага, нутгийн захиргааны байгууллагад тархааж, аймгийн түвшинд бодлого боловсруулах, төсөл хөтөлбөрийн мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2014 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Малын 2014 оны тооллогын маягт ҮСХ-ны даргын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан маягтаар, зааврын дагуу явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2014 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэхээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, шинээр гаргасан, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар 2013 онд ДНБ-ий 12.4 хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

I.1.Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод

1 тэмээ -1.5 бод

6 хонь – 1 бод

8 ямаа -1 бод Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1тэмээ -5 хонь

1 адуу-7 хонь

1үхэр -6 хонь

1 хонь-1 хонь

1 ямаа-0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу-3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр -2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал- тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ –өмнөх оны төл 2,3 настай

Адуу-Өмнөх оны төл, 2 настай

Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **Орлого тал** нь төл бойжилт, **Зарлага тал** нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100-гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь: Буур 20-25, Азарга 12-15, Бух 35-45, Хуц, Ухна 25-30

Том малын зүй бус хорогдолд Өвчний /халдвартай, халдваргүй/ хорогдол, гэнэтийн аюулын /Цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг / хорогдол, бусад шалтгааны /малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан/ хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага Оны эхний малын тоо дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж Тэжээлийн хамгамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилүүлж тэжээлийн хамгамжийг гаргана. Үүний тулд: Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал -0.25, Гар тэжээл хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал 0.22, Үр тарианы хаягдал 0.90, Лай -0.40, Сүрэл -0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл –өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
2. Хүчит тэжээл –үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
3. Шүүст тэжээл –Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
 - Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил орно.
 - Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ

Га-гийн ургац Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын / хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлоно.

Нийт ургац Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

1.2.ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2014 онд цаг агаарын байдал тааламжтай, мал төллөлтийн 96.4 хувь, төл бойжилтын хувь 99.7 хувьтай болж оны эцсийн тоолуулсан малын тоо 16.2 хувиар өсжээ.

Аймгийн ДНБ болон ХАА-н салбарын эзлэх хувь хэмжээ /сая.төг/


Хүснэгт1

	2009	2010	2011	2012	2013	2013/2012	
						%	зөрүү
Бүгд	127433.6	184626.9	201347.8	269330.4	386685.7	143.6	117355.3
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	27653.1	30278.8	36242.6	47671.5	47949.0	132.3	277.5
ДНБ-ний дүндээ эзлэх хувь	21.7	16.4	18.0	17.7	12.4	100.0	0.0

ХАА, ойн аж ахуй, ан агнуурын ДНБ,

сая.төг, ДНБ-ний дүнд эзлэх хувь

Зураг1



II.2014 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

II.1.МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2014 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 324.2 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 16.2 хувиар буюу 15188 толгойгоор өслөө. Үүнд адуу 1361, үхэр 7361, хонь 22693, ямаа 13869 толгойгоор тус тус нэмэгдэж, тэмээ 96 толгойгоор буурч. Өнгөрсөн онтой харьцуулахад Хонгор сум

33.2 хувь буюу 43039 толгой, Орхон сум 10.8 хувь буюу 4019 толгой, Шарын гол 12.6 хувь буюу 4585 толгойгоор тус тус өсч, Дархан сум 8.5 хувь буюу 6455 толгойгоор буурсан байна.

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

Хүснэгт2

	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
						%	зөрүү
Бодоор/мян.тол/	74.9	76.8	80.2	86.7	100.7	116.1	3.4
Толгойн тоо	249821	256810	268369	279053	324241	116.2	45188
Тэмээ	717	507	434	185	89	48.1	-96
Адуу	10195	10972	11253	12812	14173	110.6	1361
Үхэр	32470	33861	35609	39240	46601	118.8	7361
Хонь	127614	124987	135966	144924	167617	115.7	22693
Ямаа	78825	86483	85107	81892	95761	116.9	13869

МАЛЫН ТОО, СУМААР

Хүснэгт3

	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	69297	46	3168	13641	31995	20447
Хонгор	172794	6	7600	18090	97633	49465
Орхон	41285	37	1647	9250	17825	12526
Шарын гол	40865	-	1758	5620	20164	13323
ДҮН	324241	89	14173	46601	167617	95761

МАЛЫН ТОО,УЛС,АЙМАГ МЯН.ТОЛГОЙ, 2011-2013 ОН Зураг2



2014 онд улсын хэмжээнд нийт 45144.3 мянган толгой мал тоологдсоны 0.6 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс тэмээ 0.1 хувь, адуу 0.5 хувь, үхэр 1.3 хувь, хонь 0.7 хувь, ямаа 0.4 хувийг тус тус эзэлж байна.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ Хүснэгт4
/мян.тол/

	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо дүнгээр/			Улсын Улсын дүнд эзлэх %		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
Бодоор	80.2	86.7	100.7	10337.3	11759	13262.7	0.8	0.7	0.8
Толгойн тоо	268.4	279.1	324.2	40920.9	45144.3	51982.6	0.7	0.6	0.6
Тэмээ	0.4	0.2	0.1	305.8	321.5	349.3	0.1	0.1	0.0
Адуу	11.3	12.8	14.2	2330.4	2619.4	2995.8	0.5	0.5	0.5
Үхэр	35.6	39.2	46.6	2584.6	2909.5	3413.9	1.4	1.3	1.4
Хонь	136.0	144.9	167.6	18141.4	20066.4	23214.8	0.7	0.7	0.7
Ямаа	85.1	82.0	95.8	17558.7	19227.6	22008.9	0.5	0.4	0.4

ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

Хүснэгт5

	2010	2011	2012	2013	2014	2014/2012		2014/2013	
						%	өсөлт	%	өсөлт
Малтай өрхийн тоо	2883	2752	2412	2476	2467	102.3	55	99.6	-9
Бодоор	72542	75238	78276	84774	98934	126.4	20658	116.7	14160
Толгойн тоо	241577	248990	258800	270013	316810	122.4	58010	117.3	46797
Тэмээ	639	424	385	185	89	23.1	-296	48.1	-96
Адуу	10060	10828	10960	12601	13925	127.1	2965	110.5	1324
Үхэр	32192	33690	35165	38856	46104	131.1	10939	118.7	7248
Хонь	120673	118344	128595	137858	162231	126.2	33636	117.7	24373
Ямаа	78013	85704	83695	80513	94461	112.9	10766	117.3	13948

НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Хүснэгт 6


	2009	2010	2011	2012	2013	2014
Тэмээ	0.1	0.3	0.2	0.2	0.1	0.0
Адуу	3.1	4.1	4.3	4.2	4.6	4.4
Үхэр	10.4	13.0	13.2	13.3	14.1	14.4
Хонь	48.8	51.1	48.7	50.7	51.9	51.7
Ямаа	37.6	31.6	33.7	31.7	29.3	29.5
Бүгд	100	100	100	100	100	100

2014 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ адуу, үхэр, хонь, ямаан сүргийн өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 50.2 хувийг хонь, 16.3 хувийг үхэр, 30.7 хувийг ямааны өсөлт хангасан байна.

Нийт малын сүргийн бүтцээс харвал 51.7 хувийг хонь, 29.5 хувийг ямаа, 14.4 хувийг үхэр, 4.4 хувийг адуу 0.03 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2014 ОН

Зураг3



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт7

	2010	2011	2012	2013	2014
Бүгд	129983	122465	129773	133821	152747
Ингэ	264	268	195	90	34
Гүү	3175	3380	3444	3905	4460
Үнээ	14728	15413	15523	16809	20544
Эм хонь	68197	62548	68822	72869	81777
Эм ямаа	43619	40856	41789	40148	45932

Хээлтэгч мал нийт малын 47.1 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 38.2 хувь, адуун сүргийн 31.5 хувь, үхэр сүргийн 44.1 хувь, хонин сүргийн 48.8 хувь, ямаан сүргийн 48.0 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50-55 хувь, бог малын хувьд сүргийн 60-65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 38.2, бог малд 48.8 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ Х УВЬ

Хүснэгт8

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Бүгд	45.0	46.7	46.9	52.0	47.7	48.4	48.0	47.1
Ингэ	42.7	38.1	42.7	36.8	52.9	44.9	48.6	38.2
Гүү	29.0	26.1	28.6	31.1	30.8	30.6	30.5	31.5
Үнээ	41.3	40.7	42.6	45.4	45.5	43.6	42.8	44.1
Эм хонь	46.8	49.2	48.3	53.4	50.0	50.6	50.3	48.8
Эм ямаа	45.4	46.8	47.7	55.3	47.2	49.1	49.0	48.0

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт9

Сумын нэр	2012	2013	2014	Үүнээс					Оны эхний хээлтэгчид эзлэх %	Өмнөх оноос зөрүү /- +/
				Ингэ	Гүү	Үхэр	Эм хонь	Эм ямаа		
Дархан	1713	3595	1806		90	626	553	537	5.0	-1789.0
Хонгор	2708	6815	1645		139	337	605	564	2.6	-5170.0
Орхон	1599	1194	1478	1	69	410	442	556	9.0	284.0
Шарын гол	3362	1441	1106		56	211	450	389	6.4	-335.0
ДҮН	9382	13045	6035	1	354	1584	2050	2046	4.5	-7010.0

ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт10

Малын төрөл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014/ 2013
										%
ДҮН	1275	1329	1286	1190	2499	1474	2997	10357	671	6.5
Ингэ	0	0	0	1	2	3	0	28	0	0.0
Гүү	90	51	49	113	300	50	112	385	11	2.9
Үнээ	124	45	51	64	640	97	142	1679	58	1.7
Эм хонь	617	658	467	368	4542	610	1000	4712	193	4.1
Эм ямаа	444	575	719	644	6571	714	1743	3553	409	11.5

Оны эхний төллөх насны хээлтэгч малын 6.5 хувьтай тэнцэх 671 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо өмнөх оноос 9686 толгойгоор буюу 93.5 хувь буурсан байна.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 11.1 хувь буюу 671 хээл хаясан хээлтэгч, үлдсэн 88.9 хувь буюу 5364 сувайрсан хээлтэгч байна.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

Хүснэгт11

Малын төрөл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014 /2013
										%
ДҮН	2076	3562	5365	3150	12935	7837	6317	2651	5364	202.3
Ингэ	0	1	0	0	2	20	31	0	1	
Гүү	193	163	265	348	412	226	341	99	343	346.5
Үнээ	144	461	928	718	1899	1147	1116	128	1526	1192.2
Эм хонь	1142	1561	2266	933	5681	3777	2799	1086	1857	171.0
Эм ямаа	597	1376	1906	1151	4941	2667	2030	1338	1637	122.3

Зураг4



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт12

Малын төрөл	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2013/2012
										%
ДҮН	1550	2004	2626	2689	1945	2147	2059	2151	2463	114.5
Буур	4	7	9	13	12	9	8	5	3	60.0
Азарга	293	279	369	396	378	415	414	464	494	106.5
Бух	190	231	304	384	325	351	328	376	484	128.7
Хуц	650	856	1112	1107	773	835	797	801	925	115.5
Ухна	413	631	832	789	457	537	512	505	557	110.3

2014 онд 2463 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2013 оныхоос 14.5 хувь буюу 312 толгойгоор өссөн байна.

НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Хүснэгт13

Малын төрөл	Үржлийн норм	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014/ 2013%
Ингэ	20-25	36	23	21	14	22	30	24	18	11	61
Гүү	12-15	7	8	7	8	8	8	8	8	9	113
Үнээ	35-45	47	47	44	42	45	44	47	45	42	93
Эм хонь	25-30	62	56	72	77	88	75	86	91	88	97
Эм Ямаа	25-30	80	68	78	82	95	76	82	80	82	103

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малыг хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 88 эм хонь, ямааны хувьд 82 ногдож байгаа нь 2.6 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

Хүснэгт14

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой	Хувь
	2012	2013	2014	2012	2013	2014	2014 /2013	2014 /2013
Бүгд	268.4	279.1	324.2	100.0	100.0	100.0	45.1	116.2
Төл өсвөр насны	95.2	100.1	122.3	35.4	35.9	37.7	22.2	122.2
Ажлын ба бэлтгэл насны	41.3	43.0	46.7	15.4	15.4	14.4	3.7	108.6
Хээлтэгч	129.8	133.8	152.7	48.4	47.9	47.1	18.9	114.1
Хээлтүүлэгч	2.1	2.2	2.5	0.8	0.8	0.8	0.3	113.6

СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2014 ОН

Зураг5



МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2014 ОН

Хүснэгт15

	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	Хээлтүүлэгч	БҮГД
Дархан	100.0	39.3	13.9	46.1	0.7	75.8
Хонгор	100.0	35.9	14.9	48.5	0.7	129.8
Орхон	100.0	42.1	13.3	43.8	0.8	37.3
Шарын гол	100.0	44.4	8.2	46.6	0.8	36.3
ДҮН	100.0	37.7	14.4	47.1	0.8	279.1

2014 оны байдлаар нийт малын 37.7 хувь буюу 122.3 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 14.4 хувь буюу 46.7 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба

бэлтгэл насны мал, 47.1 хувь буюу 152.7 мянган толгой нь хээлтэгч мал, 0.8 хувь буюу 2.5 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна.

II.2.МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

2014 онд оны эхний нийт малын 29.2 хувьтай тэнцэх 81530 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2013 оныхоос 24224 толгой буюу 22.9 хувиар буурсан байна. Малтай нэг өрхийн дундажаар 33 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 3 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Оны эхний тэмээний 61.1 хувь, адууны 16.0 хувь, үхрийн 20.5 хувь, хонины 32.3 хувь, ямааны 29.9 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 87.5 хувийг бог мал, 12.5 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл малаа хэрэглээндээ хамгийн ихээр зарцуулсан Хонгор сум 53.3 мянган толгой, Дархан сум 36.9 мянган толгой, Шарын гол сум 13.4 мянган толгой, Орхон сум 2.1 мянган толгойг тус тус зарцуулав.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Хүснэгт16

Сумдын нэр	2012	2013	2014	Үүнээс				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дархан	22437	36945	41847	61	1696	5008	21167	13915
Хонгор	97051	53304	19361	0	159	266	14278	4658
Орхон	50936	2114	10510	57	255	1673	5796	2729
Шарын гол	12288	13391	9812	0	257	1093	5239	3223
ДҮН	182712	105754	81530	118	2367	8040	46480	24525

Хүснэгт17


Сумдын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2014/2013	
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	%	зөрүү
Дархан	55.2	71.8	44.5	37.5	59.8	60.2	113.3	4902
Хонгор	14.9	0.0	2.8	2.1	14.6	12.9	36.3	-33943
Орхон	28.2	57.0	15.5	20.2	34.9	25.5	4 дах.их	8396
Шарын гол	27.0	0.0	14.6	22.2	29.4	27.1	73.3	1103
ДҮН	29.2	63.8	18.5	20.5	32.1	29.9	77.1	-24224

II.3.ТӨЛ БОЙЖИЛТ

2014 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 96.4 хувь буюу 128297 эх төллөж гарсан төлийн 99.7 хувийг буюу 128383 төл бойжуулав. Бойжуулсан төлийн тоо 2013 оныхоос 8895 толгойгоор буюу 7.4 хувиар нэмэгджээ.

Бойжуулсан төл, сумаар, /толгой/

Зураг6



Бойжуулсан төл, толгойгоор, олон жилээр

Хүснэгт18

Онууд	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
2000	60430	9	1981	8932	33259	16249
2006	56288	19	1627	6904	27536	20202
2007	82302	66	1877	8561	39635	32163
2008	99980	87	1912	9390	47993	40598
2009	145372	104	2190	12163	73815	57100
2010	85969	115	2076	10575	45115	28088
2011	112662	141	2440	12517	60121	37443
2012	115756	111	2825	14389	60071	38360
2013	119488	88	2987	13725	4188	13193
2014	128383	38	3511	15605	70421	38808
2014/2013	107.4	43.2	117.5	113.7	1681.5	294.2
Зөрүү	8895	-50	524	1880	66233	25615

ТӨЛ БОЙЖИЛТ, СУМААР, ТАВАН ТӨРЛӨӨР, 2014 ОН

Хүснэгт19

Сумын нэр	Бүгд	ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ					Бүгд	ХОРОГДСОН ТӨЛ				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Дархан	35270	27	1067	5352	17779	11045	49	0	2	4	6	37
Хонгор	63057	1	1725	5761	37492	18078	115	0	6	8	53	48
Орхон	15061	10	328	2692	7341	4690	84	0	2	3	48	31
Шарын гол	14909	0	407	1825	7911	4766	175	0	6	10	117	42
ДҮН	128297	38	3527	15630	70523	38579	423	0	16	25	224	158

Хүснэгт20

Сумын нэр	Бүгд	БОЙЖСОН ТӨЛ					Төллөлтийн хувь	Бойжилтын хувь	ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕ		
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа			Төлийн хорогдол	Урьд онтой харьцуулсан %	Урьд оноос зөрүү +/-
Дархан	35682	27	1065	5348	17887	11355	96.8	99.9	49	155.7	160
Хонгор	62946	1	1719	5753	37439	18034	100	99.8	115	44.2	-262
Орхон	15008	10	326	2689	7293	4690	91.9	99.4	84	44	-341
Шарын гол	14747	0	401	1815	7802	4729	86.3	98.8	175	88.4	-82
ДҮН	128383	38	3511	15605	70421	38808	96.4	99.7	423	74.7	-279

100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

Хүснэгт21

	2000	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014 /2013 %
БҮГД	73	84	97	96	90	51	87	95	90	96	106.7
Ботго	30	42	46	53	54	61	53	41	45	42	93.3
Унага	52	77	89	83	81	66	77	84	83	90	108.4
Тугал	63	82	95	87	92	66	85	83	86	93	108.1
Хурга	75	84	98	100	92	53	88	96	94	97	103.2
Ишиг	79	87	97	95	88	43	86	94	86	97	112.8

Гарсан ботго 100 хувь, унаганы 99.5 хувь, тугалын 99.8 хувь, хурганы 99.7 хувь, ишигний 99.6 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад унага 8.4 хувь буюу 524 толгой, тугал 8.1 буюу 1880 толгой, хурга


3.2 хувь буюу 4383 толгой, ишиг 12.8 хувь буюу 2158 толгойгоор тус тус нэмэгдэж, ботго 6.7 хувь буюу 50 толгойгоор буусныг дээрх хүснэгтээс харж болно.

2000 онд 100 эхээс 73 төл бойжуулж байсан бол 2007 онд үүнээс 24 толгойгоор, 2008 онд 23 төлөөр, 2009 онд 17 төлөөр, 2011 онд 14 төлөөр, 2014 онд 23 төлөөр буюу 31.5 хувиар өсөж, 100 эх малаас 96 төл авсан байна. 2010 оныг 2000 онтой харьцуулахад 22 төлөөр буурч 100 эх малаас 51 төл авсан байна.

Таван төрлөөр авч үзэхэд 2013 оныхоос унага 7 төл буюу 8.4 хувиар, тугал 7 төл буюу 8.1 хувь, хурга 3 төл буюу 3.2 хувь, ишиг 11 төл буюу 12.8 хувиар тус тус өссөн байна. Ботго 3 төл буюу 6.7 хувиар буурсан.

II.4.Том малын зүй бүс хорогдол

Зураг7



2014 онд оны эхний нийт малын 0.6 хувьтай тэнцэх 1645 толгой мал хорогдсон нь 2013 оныхоос 1781 толгойгоор буюу 52 хувиар буурсан байна. Нийт хорогдсон малын 24 хувийг ямаа, 56.5 хувийг хонь, 12.4 хувийг үхэр, 5.8 хувийг адуу, 1.3 хувийг тэмээ эзэлж байна. Өвчнөөр 114 толгой мал хорогдсон нь нийт

хорогдолын 6.9 хувийг эзэлж, 412 толгой хээлтэгч мал хорогдсон нь нийт хорогдолын 25 хувийг тус тус эзэлнэ.

ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ

Хүснэгт22

	Өвчнөөр хорогдсон, бүгд				Зүй бус хорогдолд эзлэх хувь			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
Тэмээ	5	0	0	0	13.9	0	0	0
Адуу	10	19	17	4	10	12.6	8.9	4.2
Үхэр	27	37	45	22	12.8	9.7	8.8	10.8
Хонь	59	111	187	72	6.1	12.3	12.4	7.7
Ямаа	34	55	111	16	3.5	8.2	9.4	4.1
БҮГД	135	222	360	114	5.9	10.5	10.5	6.9

2014 ОНЫ ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, СУМААР

Хүснэгт22

Сумын нэр	Хорогдол Бүгд	Үүнээс					2013 оны хорогдол	Оны эхний малд эзлэх
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Дархан	270	5	12	41	114	98	1163	0.4
Хонгор	546	0	38	96	301	111	905	0.4
Орхон	479	16	12	35	297	119	834	1.3
Шарын гол	350	0	34	32	218	66	524	1
ДҮН	1645	21	96	204	930	394	3426	0.6

Зүй бусаар хорогдсон малын тоог сумдаар авч үзвэл Дархан, Хонгор, Орхон Шарын гол сумын хорогдол буурч аймгийн хэмжээний хорогдлын дүн буурахад нөлөөлсөн болно.

ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ

Хүснэгт23

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Бүгд	292	211	1869	46122	2287	2122	3426	1645
Тэмээ	1	6	2	34	36	20	33	21
Адуу	23	24	31	438	100	151	191	96
Үхэр	53	61	245	4151	211	381	513	204
Хонь	132	55	797	19142	971	902	1505	930
Ямаа	83	65	794	22357	969	668	1184	394

ОНЫ ЭХНИЙ МАЛД ЗҮЙ БУС ХОРОГДЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ


Хүснэгт24

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014 /2013
Бүгд	0.1	0.1	0.5	18.5	0.9	0.8	1.3	0.6	46.2
Тэмээ	0.3	1.2	0.5	4.7	7.1	4.6	7.6	11.4	150.0
Адуу	0.3	0.2	0.3	4.3	0.9	1.3	1.7	0.7	41.2
Үхэр	0.2	0.2	0.7	12.8	0.6	1.1	1.4	0.5	35.7
Хонь	0.1	0.0	0.5	15.0	0.8	0.7	1.1	0.6	54.5
Ямаа	0.1	0.0	0.6	28.4	1.1	0.8	1.4	0.5	35.7

II.5 МАЛЫН ХУЛГАЙ

Малын хулгай 2009-2014 он

Зураг8



2014 онд 32 толгой мал хулгайд алдаж, өмнөх оныхоос 22 хувиар буурсан байна.

II.6. ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

Хүснэгт 25

	Малтай өрхийн тоо			Дүнд эзлэх хувь			Малын тоо		
	2012	2013	2014	2012	2013	2014	2012	2013	2014
10 хүртэлх малтай	863	871	749	35.8	35.2	30.3	4759	4827	4124
11-30 малтай	474	472	512	19.7	19.1	20.7	8519	8632	9569
31-50 малтай	168	191	165	7.0	7.7	6.7	6694	7557	6480
51-100 малтай	231	234	244	9.6	9.5	9.9	16846	16930	17778
101-200 малтай	253	283	282	10.5	11.4	11.4	36629	40466	40299
201-500 малтай	302	295	365	12.5	11.9	14.7	94779	94921	116395
501-999 малтай	95	108	124	3.9	4.4	5.0	61740	71702	82796
1000-1499 малтай	26	22	32	1.1	0.9	1.3	28834	24978	35602
1500-2000 малтай	0	0	2	0.0	0.0	0.1	0	0	3767
2000 дээш малтай	0	0	0	0.0	0.0	0.0	0	0	0
ДҮН	2412	2476	2475	100.0	100.0	100.0	258800	270013	316810

Мал бүхий 2475 өрхийг малын тоогоор нь бүлэглэн авч үзвэл, 30.2 хувь буюу 749 өрх нь 10 хүртэл малтай: 20.7 хувь нь буюу 512 өрх нь 11-30 малтай: 6.7

хувь буюу 165 өрх нь 31-50 малтай: 9.9 хувь буюу 244 өрх нь 51-100 малтай: 11.4 хувь буюу 282 өрх нь 101-200 малтай: 14.7 хувь буюу 365 өрх нь 201-500 малтай: 5 хувь буюу 124 өрх нь 501-999 малтай: 1.3 хувь буюу 32 өрх нь 1000-1499 малтай; 0.1 хувь буюу 2 өрх нь 1500-2000 малтай өрх байна.

II.7. Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж,

2014 онд аймгийн хэмжээгээр 28684 тонн тэжээл үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 9.2 хувь буюу 2424.9 тонноор өслөө.

Тэжээл бэлтгэл /тн/

Хүснэгт26

	2010	2011	2012	2013	2014	2014/2013
Хадлан өвс	59277.8	54703	60121.6	55043	61660	112.0
Таримал тэжээл	68.5	51.4	56.8	31.9	31.7	99.4
Даршны ургамал	750	1041	1100	561.2	186.5	33.2
Гар тэжээл, хужир шүү	945.4	750.4	760	817.7	244	29.8
Төмс хүнсний ногооны хаягдал	70.2	85	85	200	270.2	135.1
Үр тарианы хаягдал	332.4	98	93	561.2	594.9	106.0
Лай	0	0	0	0	77.1	0.0
Сүрэл	80	200.2	250	61.8	38.3	62.0
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	28121.8	29215.9	29261.3	26259.1	28684	109.2

Тэжээл хангамж

Хүснэгт27

	2010	2011	2012	2013	2014	2014/ 2013%
Үйлдвэрлэсэн тэжээл бүгд (тэж.нэгж шилжүүлсэн)	28121.8	29215.9	29261.3	26259.1	28684.0	109.2
Нийт малыг хонин толгойд шилжүүлсэн /Мянган тол/	468.3	485.3	507.2	544.7	633.1	116.2
Хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл, тэж.нэгж, кг	60	60.2	57.7	48.2	45.3	94.0

II.8.Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт

Малчдын ахуй, соёлын зарим үзүүлэлт, өрхийн тоогоор, жилээр

Хүснэгт28

	Өрхийн тоо						Малчин өрхийн тоонд эзлэх хувь					
	2009	2010	2011	2012	2013	2014	2009	2010	2011	2012	2013	2014
Цахилгаантай	1106	1133	1245	901	1005	1166	84.5	94	94.6	95.7	98.5	100.0
Телевизортой	796	1175	1265	742	928	1125	60.8	97.5	96.1	78.9	91.0	96.5
Автомашинтай	527	705	1237	730	853	706	40.3	58.5	94	77.6	83.6	60.5
Мотоцикльтой	146	142	337	236	302	330	11.2	11.8	25.6	25.1	29.6	28.3
Худагтай	110	115	98	438	465	680	8.4	9.5	7.4	46.5	45.6	58.3


2014 оны тооллогоор нийт малчин өрхийн 100 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 96.5 хувь нь телевизортой, 60.5 хувь нь авто машинтай, 28.3 хувь нь мотоцикльтой, 58.3 хувь нь худагтай гэсэн дүн гарсан байна.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хангах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна.

Тайлант жилд малчдын ахуйн үзүүлэлт болох цахилгааны эх үүсгүүр, болон телевизтой, мотоцикльтой өрхийн тоо нэмэгдсэн байна.

Малчдын нийгэм ахуйн үзүүлэлт

Зураг9




МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР

Хүснэгт29

	Хэмжих нэгж	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2014/2013		
									хувь	зөрүү	
Малтай өрх	тоо	2546	2746	3029	2752	2412	2476	2467	99.6	-9	
Малчин өрх	тоо	1121	1309	1218	1316	941	1020	1166	114.3	146	
Малчдын тоо	тоо	2521	2822	3206	3784	1837	1972	2223	112.7	251	
Үүнээс:	16-34 насны	хүн	845	987	904	981	577	592	586	99.0	-6
	35-аас тэтгэврийн нас хүртэл	хүн	1119	1223	1616	1986	1037	1132	1350	119.3	218
	Тэтгэврийн насны	хүн	557	612	686	817	223	248	287	115.7	39
Нийт малчдаас эмэгтэй		хүн	1291	1136	1321	1673	804	948	1060	111.8	112
Насны бүтэц хувь		%	100	100	100	100	100	100	-	0	
Үүнээс:	16-34 насны	%	33.5	35	28.2	25.9	31.4	30	26.4	-	-3.6
	35-аас тэтгэврийн нас хүртэл	%	44.4	43.3	50.4	52.5	56.4	57.4	60.7	-	3.3
	Тэтгэврийн насны	%	22.1	21.7	21.4	21.6	12.1	12.6	12.9	-	0.3

МАЛЧДЫН БҮТЭЦ, ХУВИАР, 2013 ОН

Зураг10



II.9. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО НАСНЫ БҮЛГЭЭР

Хүснэгт 30

Сумдууд	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	16-гаас дээш насны малчдын тоо	малчид насаар			Эмэгтэй малчид
				16-34 настай	35-59 насны эр, 35-54 насны эм	Эр 60, эм 55-аас дээш насны	
Дархан	817	308	565	120	378	67	273
Хонгор	802	491	962	314	523	125	458
Орхон	421	224	424	84	285	55	200
Шарын гол	427	143	272	68	164	40	129
Дүн	2467	1166	2223	586	1350	287	1060


Аймгийн хэмжээгээр 2014 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 2467 өрх тоологдсон байна. Үүний 47.3 хувь буюу 1166 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 52.7 хувь буюу 1301 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2014 онд дүнгээр 2223 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 26.4 хувь нь 16-34 настай, 60.7 хувь нь 35-59 насны 12.9 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна.

2014 онд малчин өрхийн тоог 2013 оныхтой харьцуулахад 14.3 хувь буюу 146 өрхөөр нэмэгджээ.

II.11.МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, СҮҮЛИЙН ТАВАН ЖИЛЭЭР

Зураг11



МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО,СУМААР,

СҮҮЛИЙН ДӨРВӨН ЖИЛЭЭР

Хүснэгт 31

Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малчин өрхийн тоо			
	2011	2012	2013	2014	2011	2012	2013	2014
Дархан	1128	933	888	817	519	276	284	308
Хонгор	694	677	731	802	427	378	395	491
Орхон	465	350	432	421	218	153	203	224
Шарын гол	465	452	425	427	152	134	138	143
ДҮН	2752	2412	2476	2467	1316	941	1020	1166

ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ

ДУНДАЖ ҮНЭ, ХАНШ /төгрөгөөр/

Хүснэгт 32

	Хэмжих нэгж	2011	2012	2013	2014	2014/2013%
Ямааны ноолуур	кг	45000	40000	50000	50000	100.0
Адууны шир	ш	32000	34000	30000	39500	131.7
Үхрийн шир	ш	36000	33000	35000	47500	135.7
Хонины арьс	ш	17000	8000	9000	2500	27.8
Ямааны арьс	ш	21000	21000	24000	17500	72.9

III. ГАЗАР ТАРИАЛАН

III.1 Тариалсан талбай

Аймгийн хэмжээгээр 2014 онд нийт 18923.9 га-д тариалалт хийсэн нь 2013 оныхоос 480.4 га-гаар буюу 2.6 хувиар өссөн байна.

2013 онд тариалсан талбайг ургамлын нэр төрлөөр авч үзвэл: 11030.5 га-д үр тариа, 591.2 га-д төмс, 1341.4 га-д хүнсний ногоо, 319.7 га-д малын тэжээл, 5641.1 га-д малын тэжээл тариаллаа.

ТАРИАЛСАН ТАЛБАЙ, ГА

Хүснэгт 33

	2009	2010	2011	2012	2013	2014	2014/2013%
Бүгд талбай	12064.4	13704.8	14289.9	15469.2	18443.5	18923.9	102.6
Үр тариа	8659	6823	11041.4	9050.9	10640.5	11030.5	103.7
Үүнээс буудай	8619	6440	10384.4	9050.9	10640.5	11030.5	103.7
Төмс	1085.4	960	1001.8	1189.5	694.6	591.2	85.1
Хүнсний ногоо	600	916.8	916.7	961.6	1240.5	1341.4	108.1

III.2Хураасан ургац

Аймгийн хэмжээнд 2014 онд 14937 тн үр тариа, 7327.6 тн төмс, 17085.8 тн хүнсний ногоо, 489.1 тн тэжээлийн ургамал, 3948.1 тн техникийн ургамал 61660.4 тн өвс хадлан, 31.7 тн таримал тэжээл бэлтгэсэн нь 2013 оныхоос үр тариа 27.7 хувь, хүнсний ногоо 11.8 хувиар тус тус өсч, төмс 13.0 хувиар буурсан байна. Байгалийн өвс хадлан 12 хувиар буюу 6617.4 тн-оор өссөн байна.

ХУРААСАН УРГАЦ

/тн/ Хүснэгт 34

	2009	2010	2011	2012	2013	2014	2014/ 2013%
Нийт ургац	31871.2	29556.9	50995.2	43707.7	37912	43787.6	115.5
Үр тариа	9642.6	9737.6	16803.8	12820.8	11698	14937	127.7
Үүнээс буудай	9598.1	9147.7	16295.8	12820.8	11698	14937	127.7
Төмс	13626.6	13645.6	14276.5	14208	8418	7327.6	87.0
Хүнсний ногоо	7829.6	7829.5	13144.7	12928.9	15277.9	17085.8	111.8

ХУРААСАН УРГАЦ, СУМААР, ТӨРЛӨӨР

Хүснэгт 35

Сумын нэр	Үр тариа		Төмс		Хүнсний ногоо	
	Хураасан талбай /га/	Авсан ургац/тн/	Хураасан талбай /га/	Авсан ургац /тн/	Хураасан талбай /га/	Авсан ургац /тн/
Дархан			91.0	1356.6	133.1	2655.5
Хонгор	10990.5	14873.0	250.0	2750.0	129.1	1539.0
Орхон	40.0	64.0	200.7	2982.8	1067.0	12805.6
Шарын гол			49.5	238.2	12.2	85.7
ДҮН	11030.5	14937.0	591.2	7327.6	1341.4	17085.8

Хураасан ургацыг сумаар авч үзвэл Хонгор сум га-гаас 13.5 цн үр тариа, га-гаас 110 цн төмс, га-гаас 119.2 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт хураасан үр тарианы 99.6 хувь, төмсний 37.5 хувь, хүнсний ногооны 9.0 хувийг эзэлнэ. Үүний дараа Орхон сум га-гаас 16 цн үр тариа, га-гаас 148.6 цн төмс, га-гаас 120.0 цн хүнсний ногоо хураан авсан нь нийт үр тарианы 0.4 хувь, төмсний 40.7 хувийг, хүнсний ногооны 74.9 хувийг тус тус эзэлнэ. Үлдсэн хувийг бусад сумууд эзлэх байна.

МАЛЫН ӨСӨЛТӨНД ГОЛЛОН НӨЛӨӨЛСӨН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүснэгт 36

	2009	2010	2011	2012	2013	2014	2014/2013	
							%	зөрүү
Бойжуулсан төл	145372	85969	112662	115756	119488	128383	107.4	8895
100 эхээс бойжуулсан төл	90	51	87	95	90	96	106.7	6
Зүй бус хорогдол	1869	46122	2287	2122	3426	1645	48.0	-1781
Хээлтэгчийн тоо	169487	129983	122465	129773	133821	152747	114.1	18926
Хээл хаясан	1190	2494	1474	2997	10357	671	6.5	-9686
Сувайрсан	3150	12935	7837	6317	2651	5364	2д.и	2713

ДҮГНЭЛТ

2014 оны мал тооллогын дүнгээр 324241 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 45188 толгой малаар буюу 16.2 хувиар өслөө. Нийт тоологдсон малын 99 хувийг амины мал эзэлж байна.

2014 онд аминдаа малтай 2467 өрх байгаагийн 1166 нь малчин өрх байна. Мал аж ахуйн салбарт нийт 2223 малчид ажиллаж байна.

Нэг малчин өрхөд дундажаар 128 толгой мал, үүний дотор адуу 6, үхэр 18, хонь 66, ямаа 38 ногдож байна.

Мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлд цаашид нэг малын ашиг шим, чанарын үзүүлэлтэд анхаарлаа хандуулж, энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа мал аж ахуйн салбарт шинэчлэл хийж, ашиг шим өндөртэй мал өсгөж үржүүлэх, малыг суурин болон бэлчээрийн хосолсон маллагаанд шилжүүлэх, малчдын хөдөлмөрийг хоршуулах, бэлчээрийг усжуулахад чиглэсэн арга хэмжээ ихээхэн чухал байна.

2014 онд тариалсан талбайг ургамалын нэр төрлөөр авч үзвэл: үр тариа 11030.5 га, улаан буудай 11030.5 га, төмс 591.2 га, хүнсний ногоо 1341.4 га, малын тэжээл 319.7 га, рапс 5641.1 га-д тариаллаа. Аймгийн хэмжээгээр үр тариа, хүнсний ногоо, малын тэжээлийн тариалалт нэмэгдсэн байна. Тухайлбал: 14937 тн үр тариа, 7327.6 тн төмс, 17085.8 тн хүнсний ногоо, 489.1 тн тэжээлийн ургамал, 3948.1 тн техникийн ургамал 61660.4 тн өвс хадлан, 31.7 тн таримал тэжээл бэлтгэсэн нь 2013 оныхоос үр тариа 27.7 хувь, хүнсний ногоо 11.8 хувиар тус тус өсч, төмс 13.0 хувиар буурсан байна. Байгалийн өвс хадлан 12 хувиар буюу 6617.4 тн-оор өссөн байна.

Газар тариалангийн үйл ажиллагаанд байгаль, цаг уур ихээхэн нөлөөлж байгаа боловч цаашид ургац хураалтын хэмжээг боломжийн хэмжээнд байлгахын тулд га-гийн ургацыг нэмэгдүүлэх, үүний тулд чанартай сайн үр суулгах, ургац боловсролтын үед хортон шавьжтай тэмцэх, иргэдийн дунд тариалалт хийх, ургац

хураах зэрэг асуудлаар сургалт, сурталчилгаа явуулж, мэдлэгийн дээшлүүлэх зэрэгт ихээхэн анхаарах шаардлагатай байна.

Хамгийн гол асуудал бол хөдөө орон нутагт хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг хадгалах, боловсруулах, борлуулах чиглэлээр жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх төвлөрсөн цэгүүд, хадгалах, хөргөх агуулах, зоорийг бий болгох, сэргээх нь чухал байна.

Бэлчээрийн мал маллагаанд нутгийн шилмэл омог үүлдрийн малыг өөр дотор шилж сонгон цэвэр үржүүлгийн арга хэрэглэх, нутгийн үүлдэр шилмэл омгийн малаар сайжруулах төв суурин газрын хувьд сүүний чиглэлийн үхэр, адуу, тэмээ, ямааны эрчимжсэн фермерийн аж ахуй байгуулж эрхлэхийг дэмжих.

Мал сүргийг байнгын даатгалд хамруулах, байгалийн гамшиг, зудын хохиролоос сэргийлэх арга хэмжээ авах.

Малчдын боловсрол, мэргэжилтэй залуу халааг бэлтгэх арга хэмжээ авах

Хадлан, тэжээл үйлвэрлэлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зэрэг арга хэмжээнүүдийг авах шаардлагатай байна.

Ашигласан ном, материал

1. Дархан –Уул аймгийн Статистикийн эмхэтгэл 2014 он
2. Улсын Статистикийн эмхтгэл 2013 он
3. Хөдөө аж ахуйн салбар 2014 он, ҮСХороо
4. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
5. Аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын танилцуулга -2014 он
6. Дархан-Уул аймгийн Хөдөө аж ахуйн салбар, 2013 он
7. Хөдөө аж ахуйн 2011 оны улсын анх дугаар тооллого, 2012 он
8. "Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал" танилцуулга, 2014/12 сар
9. WWW.1212.mn